



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.18-2022.04.22



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.22-ны after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	33,566.00	-0.72%	-2.47%	-3.99%	-1.24%
S&P 500	4,242.45	-0.69%	-3.43%	-7.31%	1.27%
NASDAQ	13,268.00	-0.66%	-4.62%	-11.47%	-5.41%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,522.00	-1.39%	-1.05%	0.82%	8.40%
DE40	14,142.00	-2.48%	-0.08%	-0.99%	-7.44%
FR40	6,581.00	-1.99%	0.71%	0.00%	5.17%
IT40	24,280.00	-2.12%	-1.40%	-0.08%	-0.44%
ES35	8,652.00	-1.84%	-0.48%	3.89%	0.39%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,593.00	-1.89%	-1.75%	-5.07%	-8.26%
SHANGHAI	3,016.00	-2.30%	-5.82%	-6.37%	-12.54%
CSI 300	3,929.00	-2.10%	-5.96%	-5.56%	-22.83%
CH50	13,242.17	-1.97%	-4.12%	-1.33%	-22.81%
SENSEX	57,197.00	-1.23%	0.05%	-0.85%	19.54%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	99.25	-2.69%	-8.29%	-4.04%	60.30%
Газрын тос (Brent)	103.73	-2.69%	-8.37%	-5.30%	57.94%
Байгалийн хий	6.4360	-1.50%	-17.70%	16.85%	130.68%
Шатахуун	3.2352	-2.10%	-4.24%	1.21%	63.50%
Нүүрс	326.00	-1.54%	5.47%	0.31%	250.54%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,923.28	-0.33%	-2.83%	-0.02%	8.01%
Мөнгө	23.893	-0.96%	-7.45%	-3.73%	-8.76%
Зэс	4.5325	-1.05%	-5.41%	-3.78%	1.93%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.8619	0.0426	0.01%	0.40%	1.29%
Англи	1.9670	0.0450	0.08%	0.26%	1.23%
Швейцар	0.9250	0.0170	-0.03%	0.44%	1.25%
Испани	1.9440	0.0000	0.17%	0.58%	1.56%
Португаль	2.0030	0.0060	0.15%	0.73%	1.60%


Эх сурвалж: Trading economics

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Бондын зах зээл юуг дохиж байна вэ?

Инфляц: 2022 он гарснаар урт болон богино хугацаат бондын өгөөж хүчтэй өссөн. Жишээлбэл, 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж энэ жил 1.4%-иар өссөн бол 2 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 1.9%-иар өссөн юм. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь инфляцын түвшин сүүлийн 40 жилд үзэгдээгүй дээд хэмжээнд хүрсэнтэй холбоотой. Хэдий шинжээчид болон эрх баригчид нийлүүлэлтийн гинжин холбооны гацаанаас болж инфляцын түвшин өссөн гэж тайлбарлаж байсан боловч Орос-Украины дайн эхэлснээр түүхий эдийн ханш огцом нэмэгдсэнээр, эрчим хүчний үнийг өсгөж инфляцад нөлөөлсөн.

АНУ-ын инфляцын түвшин /хувиар/



ХНС-аас илүү хатуу мөнгөний бодлого баримтлах чиг хандлагатай болов: ХНС-аас сүүлд өгсөн мэдээллээр Төв банк инфляцын түвшинг зорилтод хэмжээнд аваачихаар тэмцэхэд бэлэн гэдгээ зарласан. ХНС бодлогын хүүг нэмж, балансын дүнгээ бууруулах үйлдэлтэй холбоотойгоор 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж өнгөрсөн гурван 7 хоногт 0.60%-иар өссөн. Шинжээчдийн үзэж байгаагаар энэ нь цаашид урт хугацаатай үнэт цаасны өгөөж нэмж өсөх төлөвтэй байгаа талаарх саналаа хуваалцсан.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Бодлогын хүүг ихээр нэмэх нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх вэ?

Шинжээчдийн үзэж байгаагаар бодлогын хүү өсөж буй энэ үед АНУ-ын эдийн засаг 2022 онд 2-3%-иар өснө гэж төсөөлжээ. Иргэдийн дансанд байгаа хадгаламжийн хэмжээ 2 их наяд доллар хүрсэн болон цалингийн хэмжээ жилд 5%-иар өсөж байгаа нь өрхийн хэрэглээ зээл дээр тулгуурлах шаардлага харагдахгүй байна. АНУ-д өрхийн хэрэглээ нь ДНБ-ний 70%-ийг бүрдүүлдэг тул хэрвээ өрхийн хэрэглээ хямрахгүй бол эдийн засаг хангалттай өсөх боломжтой харагдаж байна.

АНУ-ын ДНБ өсөлт /хувиар/



Source: U.S. Bureau of Economic Analysis

30 жилийн хугацаатай орон сууцны зээлийн хүү /хувиар/



Үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн том хүндрэлтэй тулгарч болзошгүй байна.

Хэдий өрхийн хэрэглээ, эдийн засаг өндөр бодлогын хүүтэй үеийг даван туулж чадах ч орон сууцны салбар хүндрэлтэй байж болзошгүй байна.

30 жилийн хугацаатай орон сууцны зээлийн хүү хагас жилийн өмнө 3% байсан бол өнөөдөр 5% болтлоо өсжээ. Орон сууцны зээлийн хүү сүүлийн 5 жил дунджаар 3.7% байснаас ингэж огцом өсөх нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хүндээр тусаж магадгүй байна.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Эдийн засгийн хямрал болох дохио хараахан болоогүй байна.

1973-2007 оны хооронд 6 удаа эдийн засгийн хямрал болоход 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж дунджаар 8.1%-тай байсан юм. Шинжээчдийн үзэж буйгаар ойрын жилүүдэд үнэт цаасны өгөөж дээрх хэмжээнд хүрнэ гэж харахгүй байна.

2001-2007 оны хямралаар үнэт цаасны өгөөж дунджаар 4.4%-д хүрч байсан. Урт хугацаат үнэт цаасны өгөөж нь богино хугацаат үнэт цаасны өгөөжөөс илүү байх хугацаанд Төв банк бодлогын хүүг хэт ихээр нэмэхгүй байх болов уу.

10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж /хувиар/



2 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж /хувиар/



Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Netflix-ийн хувьцааны ханш цаашид унах уу?

-Өнгөрсөн жилийн 11 сарын үед Netflix 308 тэрбум долларын зах зээлийн үнэлгээтэй байсан бол өдгөө 100 тэрбум доллароос бага үнэлгээтэй болжээ.

-Wallstreet-ийн шинжээчид компанийн хувьцааны үнэлгээг тодорхой бус байдалтай холбоотойгоор буулгав.


Netflix компани өнгөрсөн 7 хоногт танилцуулсан 2022 оны эхний улирлын тайландаа 200 мянган хэрэглэгч алдсан тухай тусгасан. Энэ жилийн 2-р улиралд нэмж 2 сая хэрэглэгчээ алдана гэсэн таамагтай байгаа нь хувьцааны ханшийг 35%-иар унахад нөлөөлжээ. Цар тахлын үеэр тус компани нь 2020 онд 36 сая, 2021 онд 18 сая шинэ хэрэглэгч нэмсэн юм. Өнгөрсөн 7 хоногийн хувьцааны уналтын улмаас S&P 500 болон Nasdaq индекс дээрх хамгийн их унасан хувьцаагаар тодорчээ.

Өрсөлдөөн ширүүсэв

Netflix-ийн мэдээлж буйгаар хэрэглэгчдийн хооронд нууц үгээ солилцож байгаа болон өрсөлдөөний улмаас хэрэглэгчийн тоо буурсан гэжээ. Тэдний мэдээлснээр 100 сая гаруй өрх Netflix-ийг үнэ төлбөргүй ашиглаж байна гэсэн.

Netflix-ийн өрсөлдөгч компаниудын нэг болох HBO Max 2022 оны эхний улиралд нийт 76.8 сая хэрэглэгчтэй болсон нь өмнөх жилийн мөн үеийнхээс 12.8%-иар өсжээ. Энэ нь Netflix өрсөлдөгч нартаа хэрэлцэгчдээ алдаж байгааг харуулж байна.

Netflix хэрэглэгчидийн тоо (сая ширхэг)



Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Netflix үүнээс цааш хайчих вэ?

Богино хугацаандаа энэхүү асуултад шууд хариулж чадах хүн одоогоор алга байна. Компанийн улирлын тайлан гарснаас хойш шинжээчид хувьцааны үнэлгээг буулгасан. CNBC телевизийн мэдээлж буйгаар дор хаяж 10 хөрөнгө оруулалтын байгууллага тус компанийн үнэлгээг буулгаад байгаа талаар мэдээлсэн.

Bank of America-ийн мэдээлснээр “Netflix дахиж өсөхөд цаг хугацаа орох талаар” хэлсэн юм. Хөрөнгө оруулалтын сангийн захирал William Ackman “Netflix компанийн цаашдын нөхцөл байдлыг төсөөлөхөд бэрхшээлтэй байгаа” тул өөрийн худалдан авсан хувьцааг 400 сая долларын алдагдалтай хаажээ.

Иймд Netflix хэдий сүүлийн 10 жилд асар амжилттай байсан ч үйл ажиллагаа явуулж байгаа салбарын өрсөлдөөн илүү ширүүсэж байгаа болон ирээдүйн өсөлт нь тодорхой бус байгаа тул энэхүү уналтан дээр хувьцааг авах нь оновчгүй үйлдэл байхаар харагдаж байна.

Netflix-ийн ханш



Эх сурвалж: www.edwardjones.com